МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн

МОНГОЛ УЛСЫН
“ЧИНГИС ХААН”
ҮНДЭСНИЙ МУЗЕЙ

ОХУ-ЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн

МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ:
ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

VI

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан

Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2023 оны 4 сарын 19-21
Монгол Улс, Улаанбаатар хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Улаанбаатар – Санкт-Петербург
2025

ННА 63
ДАА 900
М-694

Хариуцлагатай редактор: Академич С. Чулуун
Эмхтгэгч-редакторууд: Хэл бичгийн шинжлэх ухааны доктор И. В. Кульганек
Түүхийн ухааны доктор (Ph.D), проф Н. Хишигт
Хэл шинжлэлийн дэд эрдэмтэн Д. А. Носов

Монголчуудын соёлын өв: Гар бичмэл ба архивын баримтын цуглуулга-VI. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. 2023 оны 4 сарын 19-21. Монгол Улс, Улаанбаатар хот. Улаанбаатар – Санкт - Петербург, 2025. – 320 тал.

Тус эмхэтгэлийг Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, “Чингис хаан” Үндэсний музей, ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн хамтран 2023 оны 4 дүгээр сарын 19-21-нд Монгол Улсын Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 6 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдээр бүрдүүлэв.

Энэхүү хурлыг зохион байгуулах эх суурь нь архив, гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй монгол угсаатан ард түмнүүдийн хэл, түүх, улс төр, хэл, утга зохиол, шашин соёл, угсаатны зүйд холбогдох баримт материал болно.

Эмхэтгэлд монгол судлалын түүх, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, хээрийн шинжилгээний ангиудын тухай болон Монголын уламжлалт нийгэм, орчин үеийн амьдралын олон талт асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүдийг багтаав.

ISBN 978-9919-533-04-5
DOI 10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2025
© Монгол Улсын “Чингис хаан” Үндэсний музей, 2025
© Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2025

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии

“ЧИНГИС ХАН”
Национальный музей
Монголии

РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей

КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: РУКОПИСНЫЕ И АРХИВНЫЕ СОБРАНИЯ

VI

Международная конференция
при поддержке Президента Монголии

19-21 апреля 2023 г.
Монголия. Улан-Батор

Сборник докладов

Улан-Батор — Санкт-Петербург
2025

ННА 63
ДАА 900
М-694

Ответственный редактор: Академик С. Чулуун
Редакторы-составители: доктор филол. наук И. В. Кульганек
доктор (Ph.D), проф. Н. Хишигт
кандидат филол. наук Д. А. Носов

Культурное наследие монголов: Рукописные и архивные собрания. Сборник докладов VI Международной научной конференции. 19-21 апреля 2023. Улан-Батор, Монголия. УБ. — СПб., 2025. — 320 с.

Сборник представляет собой собрание докладов VI Международной научной конференции “Культурное наследие монголов: рукописные и архивные собрания», организованной Институтом истории и этнологии МАН, Национальным музеем Монголии Чингис-хан и Институтом восточных рукописей РАН в Улан-Баторе 19-21 апреля 2023 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, политике, языку, литературе, культуре, религии и этнографии монгольских народов.

В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-9919-533-04-5
DOI 10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Институт истории и этнологии МАН, 2025
© "Чингис-хан" Национальный музей Монголии, 2025
© Институт восточных рукописей РАН, 2025

MONGOLIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of History and
Ethnology

CHINGGIS KHAAN
NATIONAL MUSEUM
OF MONGOLIA

RUSSIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of Oriental
Manuscripts

CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

VI

International Conference
Under the Patronage of the President of Mongolia

April 19-21, 2023.
Mongolia, Ulaanbaatar

Proceedings

Ulaanbaatar – St. Petersburg
2025

ННА 63
ДАА 900
М-694

Edited and compiled by Academician S. Chuluun
D.Sc.(Philology) I. V. Kulganek
Ph.D (History), prof N. Khishigt
Cand. Sc. (Philology) D.A. Nosov

Cultural heritage of the Mongolis: Manuscripts and archival collections-VI. Papers of the VI International Conference, April 19-21, 2023. Ulaanbaatar. Ulaanbaatar-St.Petersburg 2025, 320 pages.

This is a collection of papers, presented at the Sixth International Conference organized by the Institute of History and Ethnology of the Mongolian Academy of Sciences, National Museum of Mongolia "Chinggis Khaan" and the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences, which was held in Ulaanbaatar in April 19-21, 2023.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples.

The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN 978-9919-533-04-5
10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Institute of History and Ethnology MAS, 2025
© National Museum of Mongolia "Ghinggis Khaan", 2025
© Institute of Oriental Manuscripts RAS, 2025

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ

ӨМНӨХ ҮГ 10

МЭНДЧИЛГЭЭ /ПРИВЕТСТВИЯ..... 11

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 6 дугаар удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцогсдод ирүүлсэн илгээлт..... 12

Приветственная речь Генерального секретаря Международной ассоциации монголоведения, директора Национального музея Монголии Чингис-хан, академика С. Чулууна 14

Приветствие директора Института восточных рукописей РАН, член-корреспондента РАН И. Ф. Поповой 16

Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал, (Sc.D) Ц. Цэрэндоржийн мэндчилгээ..... 18

ИЛТГЭЛҮҮД / ДОКЛАДЫ

Г. Алтансүх
Нур ад-Дины гар бичмэл дундад зууны монгол хүний нэрийн сурвалж болох нь 22

Г. Баярмаа
Берлиний Улсын номын санд хадгалагдах Монголын бурханы шашинд холбогдох баримтын тухай..... 28

Т. Баясгалан
Арташид хан хөвгүүний туужаас сэдэвлэсэн монгол тууль 43

Л. Ганбат
“Zafarnama” Монголын түүхэнд холбогдох сурвалж болох нь..... 52

Д. Дашдулам
1932 оны зэвсэгт бослогын нэгэн удирдагч Самбуу дүвчингийн тугийн талаар нэхэн үзэх нь 58

Ц. Дэлгэрсайхан
Монгол Улсын боловсролд Оросын сургагч багш, мэргэжилтнүүдийн оруулсан хувь нэмрийг архивын баримтаар тодотгох нь (1912-1942 он)..... 76

Zsolt Szilágyi
The Hungarian press perceptions of Mongolia at the beginning of the 20th century..... 89

И. М. Захарова
Караван купца Ивана Саватеева в Китай в 1702-1704 гг.
(По материалам Государственного Эрмитажа)..... 99

И. В. Кульганек
«Речь о состоянии монгольской словесности» из собрания
Института восточных рукописей РАН 108

Лицю Лю, Р. М. Валеев, Р. З. Валеева, Ю. И. Елихина, Д. Е. Мартынов
Формирование монголоведения, буддологии и тибетологии
в Казани в XIX в.: архивные фонды и материалы государственного
архива Республики Татарстан и музеев Казани 120

М. В. Мандрик
Коллекция документов по истории Русской духовной миссии
в Пекине и Монголии в собрании Научного архива ИИМК РАН 140

Д. Наранцэцэг
Хорчинба Ишжамцын намтар “Сүсэг төгөлдөр нугуудын зүрхний
энэлгийг арилгагч” хэмээх зохиолын шинжлэл 149

Б. Нацагдорж
Монгол Гэсэрийн туужийн үйсэн дээр бичсэн нэгэн эхийн тухай 162

Д. А. Носов
Загадка тетрадей Лисовского: о составе единицы хранения
« В.И. Лисовскийн тэмдэглэлийн дэвтэрүүд» из Центрального
Национального Архива Монголии 178

G.Odbayar
A Contribution to the study of Mongol bannermen: The founding policy
of the Tibetan Qing Administration, written by Sungyun 184

Э. Пүрэвжав, М. Очирцэнд
Монгол Улс дахь нутгийн аялгуу судлалыг архивын баримтаас
тодруулах нь 197

Т. Сайнжаргал
Үндэсний Төв Архивын сан хөмрөг дэх Түшээт засаг
гүн Балдардоржийн захидлын мэдээг мөшгөх нь 213

М. В. Федорова
Вклад Я. П. Шишмарева в формирование монгольского собрания
Российского этнографического музея 221

Н. Хатанбаатар
"Богд Жибзундамбын анхан төрлийн нэр оршивой" хэмээх сурвалжийн тухай 235

Н. Хишигт
О. И. Макстенек: Монголын тухай илтгэл, мэдээллүүд (1920-1921 он) 241

С. Цолмон, Ц. Энхчимэг
Еще раз о Золотоордынских тамгах Крыма 250

Ц. Цэрэндорж
Солонгосын Чосөнъ улсын үед монгол хэлний сургалтад ашиглаж байсан ном, сурах бичгүүдийн нэрийг тодруулах нь 262

S. Chuluun, Agata Bareja-Starzyńska
On the documents of the first population and statistical census of Mongolia in the 20th century kept in the archive of prof. W.Kotwicz in Cracow, Poland 274

Ц. Энхжаргал
Таван жилийн төлөвлөгөөг сайжруулах асуудалд холбогдох баримтын тойм (Монгол Улсын Үндэсний Төв Архивын материалаар) 291

ИЛТГЭГЧДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ 310

DOI 10.48612/IVRRAN/px6b-xzut-4p79 *Ц. Цэрэндорж (Монгол Улс)*

СОЛОНГОСЫН ЧОСӨНЪ УЛСЫН ҮЕД МОНГОЛ ХЭЛНИЙ СУРГАЛТАД АШИГЛАЖ БАЙСАН НОМ, СУРАХ БИЧГҮҮДИЙН НЭРИЙГ ТОДРУУЛАХ НЬ

Товч агуулга: Монгол, Солонгос хоёр улс эртнээс харилцаж ирсэн бөгөөд тэрхүү харилцааг гэрчлэх түүхийн сурвалжийн мэдээ, биет дурсгал олноор үлдэж хоцорчээ. Хоёр улсын түүхэн харилцаа дундад зууны үе буюу Монголын эзэнт гүрэн, Корйө улсын үед оргилдоо хүрсэн билээ. Харилцаа нь Корйө улсыг түлхэн унагааж түүхийн тавцанд гарч ирсэн Чосөнъ улс (1392-1910)- ын үеэс харьцангуй саарч эхэлсэн боловч бүрмөсөн тасралгүй явсаар XX зуун хүрсэн юм.

Чосөнъ улсын үед хөрш улс орнуудтай саадгүй харилцахын тулд тухайн улс орны хэлийг эзэмшсэн орчуулагч түшмэдийг бэлтгэх сургууль буюу Орчуулгын хүрээлэнг байгуулж, дөрвөн гадаад хэл зааж байсны нэг нь монгол хэл байжээ. Монгол хэлний сургалт бүр хожуу болтол буюу 1894 он хүртэл үргэлжилсэн бөгөөд сургалтад олон тооны ном, сурах бичиг ашиглаж байсны зарим нь эдүгээ биетээр үлдэн хоцорч, дийлэнх олонх нь уламжлагдан ирээгүй боловч, нэр нь түүхийн сурвалжид тэмдэглэгдэн үлджээ.

Энэхүү илтгэлд Орчуулгын хүрээлэнд монгол хэлийг заан сургаж байсан үйл явц хийгээд монгол хэлний сургалтад ашиглаж байсан сурах бичгүүдийн талаар танилцуулахыг оролдсон болно.

Түлхүүр үг: *Монгол, Чосөнъ улс, Орчуулгын хүрээлэн, монгол хэлний сурах бичиг, орчуулагч түшмэл, “Монгол судлалын гурван бичиг”, “Төр засах их цааз”*

Tserendorj Tsegmid

IDENTIFYING THE NAMES OF THE BOOKS AND MANUALS USED TO LEARN THE MONGOLIAN LANGUAGE DURING THE JOSEON DYNASTY IN KOREA

Summary: Since ancient times, the two countries Mongolia and Korea have maintained relations as attested by numerous sources, records, and physical items this relationship has left behind. Within the history of the relations between the two countries, the peak or zenith of relations between

Mongolia and Korea was reached during the medieval period with the relations established between the Mongol Empire and Goryeo. While relations between Mongolia and Korea declined after the Joseon Dynasty (1392-1910) overthrew the Goreyo, it was not extinguished and remained intact until the 20th century. During the Joseon period, in order to maintain unhindered relations with their neighboring countries and kingdoms, they trained translator officials by establishing the Institute of Translation where they taught their translator officials four foreign languages of which one was Mongolian. The teaching and learning of Mongolian continued until as far as 1894 and a number of different books and teaching manuals were used in this endevor. Of these sources, while many have been lost to the passage of time, their names remained recorded in historical sources and records.

This presentation will aim to introduce the activities of the Institute of Translation as they taught Mongolian and elucidate upon the books and manuals that were used to teach the Mongolian lanaguage.

Key words: *Mongol, Joseon Dynasty, Institute of Translation, Mongolian language manual, translation official, "The Three Texts of Mongol Studies", "The Great State Law"*

Оршил

Монгол, Солонгос хоёр улс эртнээс харилцаж ирсэн бөгөөд тэрхүү харилцааг гэрчлэх түүхийн сурвалжийн мэдээ, биет дурсгал олноор үлдэж хоцорчээ. Хоёр улсын түүхэн харилцаа дундад зууны үе буюу Монголын эзэнт гүрэн, Корйө улсын үед оргилдоо хүрсэн билээ. Харилцаа нь Корйө улсыг түлхэн унагааж түүхийн тавцанд гарч ирсэн Чосөнъ улс (1392-1910)-ын үеэс харьцангуй саарч эхэлсэн боловч бүрмөсөн тасралгүй явсаар XX зуун хүрсэн юм. Чосөнъ улсын үед хөрш улс орнуудтай саадгүй харилцахын тулд тухайн улс орны хэлийг эзэмшсэн орчуулагч түшмэдийг бэлтгэх сургууль буюу Орчуулгын хүрээлэнг байгуулж, дөрвөн гадаад хэл зааж байсны нэг нь монгол хэл байжээ. Монгол хэлний сургалт бүр хожуу болтол буюу 1894 он хүртэл үргэлжилсэн бөгөөд сургалтад олон тооны ном, сурах бичиг ашиглаж байсны зарим нь эдүгээ биетээр үлдэн хоцорч, дийлэнх олонх нь уламжлагдан ирээгүй боловч, нэр нь түүхийн сурвалжид тэмдэглэгдэн үлджээ. Энэ бүхэн нь Монгол-Солонгосын соёлын болон улс төрийн харилцааг батлан харуулах томоохон баримт юм.

Энэхүү илтгэлд Орчуулгын хүрээлэнгийн монгол хэлний сургалтад ашиглаж байсан сурах бичгүүдийн нэрийг тодруулахыг оролдов.

Монгол хэлний сургалтад ашиглаж байсан ном, сурах бичиг: Орчуулгын хүрээлэнд монгол хэлний хэлмэрч бэлтгэх сургалтад бараг 20 шахам ном, сурах бичиг ашиглаж байснаас эдүгээ "Монгол судлалын гурван бичиг (몽학삼서; 蒙學三書)" хэмээн нэрлэгдсэн гурван ном уламжлагдан иржээ. Тэдгээр нь:

- "Мон-ө ногөлдэ (몽어노걸대; 蒙語老乞大)" буюу Монгол хэлний ярианы дэвтэр
- "Мон-ө йүхэ (몽어유해; 蒙語類解)" буюу Монгол хэлний зүйл хуваасан тайлбар толь
- "Чөбхэ мон-ө (첩해몽어; 捷解蒙語)" буюу Монгол хэлний ярианы дэвтэр эдгээр болно.

Энэ гурвын дотроос хамгийн удаан хугацаанд ашиглагдсан нь "Мон-ө ногөлдэ" бөгөөд нийт 8 боть 8 дэвтэр, харилцан ярианы хэлбэртэй ном юм. Агуулгын хувьд нэгэн худалдаачны аян замын туршид тохиолдох сонирхолтой үйл явдлыг өдөр тутмын амьдралд хэрэглэгддэг үг хэллэг ба өгүүлбэрийн олон янзын хэлбэрээр илэрхийлж бичсэн байдаг. Уг бүтээл нь олон жилийн турш хэд хэдэн хувилбараар орчуулагдаж ирсэн солонгос хэлний түүхийн судалгаа төдийгүй монгол, солонгос хэлний харьцуулсан судалгааны үнэт хэрэглэгдэхүүн юм [최동권, Otgontuul: 2009].

Харин "Мон-ө йүхэ" нь эдүгээ Сөүл Их сургуулийн Кйүжангаг (규장각; 奎章閣) номын санд ганцхан хувь байдаг ба нийт гурван дэвтэртэй, 5317 үгийг 54 төрөл зүйлд хуваж оруулсан байна. Тэргүүн дэвтэрт тэнгэр, цаг улирал, газарзүй, хүн ёс, хүний зан чанар, хүний бие эрхтэн зэрэг 27 төрлийн 1916 үг орсон бол дэд дэвтэрт газар тариалан, гурил будаа, мод ургамал, жимс жимсгэнэ, өвчин эмгэг зэрэг 27 төрлийн 1926 үг, гутгаар дэвтэр буюу нөхсөн дэвтэрт тэргүүн дэвтэр, дэд дэвтэрт гарсан нэрийн 48 төрлийн 1475 үг нэмэгдсэн байна.

"Чөбхэ мон-ө" нь бүгд 4 боть, 4 дэвтэр бөгөөд модон барын хэвлэл юм. "Мон-ө ногөлдэ"-тэй адил монгол бичвэр болон түүний баруун талд ханъгыл үсгээр дуудлагыг галиглаж, доод талд нь солонгос хэлээр орчуулсан байна. Энэхүү ном нь харилцан ярианы хэлбэртэй, ёс суртахуун, эрдэм мэдлэгийн тухай агуулгатай байдаг [Баярмаа 2017: 11-12].


蒙語老乞大卷之一

*Зураг 1. “Мон-ө ноголдэ (*蒙語老乞大*)”*


捷解蒙語第一 四

*Зураг 2. “Чөбхэ мон-о (*捷解蒙語*)”*

秋 ᄀᆞᅀᆞᆯ ○나물 冬 겨ᄋᆞᆯ ○어ᄇᆞᆯ
日子 날 ○어둘 今日 오ᄂᆞᆯ ○어ᄂᆞᆯ
昨日 어제 ○위쥬거둘 明日 ᄂᆡᆯ일 ○말가라 ᄀᆞᆞᆺ아나갈
前日 그젓 ○울지 어둘 後日 모ᄅᆡ ○뉘쿠거 어둘
終日 히지도록 ○나란 우나라 ᄀᆞᆞᆺ나란 오ᄂᆞᆯ라 初一 초ᄒᆞᆫ날 ○시니 연니건
十五 站 보름 ○알ᄫᆞᆫ 타분 上弦 ᄀᆞᆞᆷ첫조 ○더거두 연 하갓
下弦 ᄀᆞᆞᆷ흣조 ○도라두 연 하갓 盡頭 금음 ○비러군
月盡 ᄃᆞᆯ그무다 ○사라 연 ᄒᆞᆫ구ᄎᆡᆫ열 大盡 ᄃᆞᆯ크다 ○사라 이ᄉᆞ거
小盡 ᄃᆞᆯ젹다 ○사라 바가 年 히 ○ᄀᆞᆞᆺ온 ᄌᆞᆫ
今年 ㅣㅣ ○어너 질ᄋᆞ 當年 그히 ○문쿠 질ᄋᆞ
時令 蒙語類解上 三

Зураг 3.
“Мон-ө йүхэ (蒙語類解)”

Анхандаа Орчуулгын хүрээлэнгийн монгол хэлний сургалтад 20 шахам ном, сурах бичиг ашиглаж байжээ. Сэжонгийн магад тэмдэглэл, “Төр засах их цааз” (경국대전; 經國大典) зэрэг сурвалж бичигт монгол хэлний сургалттай холбоотой 16 ном, сурах бичгийн нэр дурдагдсан байна.

Гэвч Хар луу жилийн (1592 он) Японы довтолгоон зэрэг дайн самууны үед зарим сурах бичиг үрэгдэж үгүй болсон, эсвэл тухайн үеийн нийгмийн байдалтай нийцэхгүй байснаас засаж өөрчлөх буюу огт өөр номоор сольсон байна. Тиймээс XVII зууны сүүлч буюу Сүгжон ван (숙종; 肅宗)-гийн үеэс эхлэн орчуулгын ном, сурах бичгийг зохион туурвих, засварлах ажил эхэлсэн бөгөөд энэхүү ажил нь XVIII зууны сүүлч үе буюу Чөнжо ван (정조; 正租)-гийн үе хүртэл үргэлжилсэн юм.

Чосөнъ улс, харийн довтолгооноос сэргийлэхийн тулд хөрөнгө болоод цэргийн хүчийг бэхжүүлэхээс илүүтэй тэдэнтэй ойлголцоход зайлшгүй шаардлагатай хэлмэрчдийг бэлтгэхэд гол анхаарлаа хандуулж байжээ. Орчуулгын сургалт зайлшгүй хэрэгцээтэй гэдэг нь Хар луу жилийн Японы довтолгоон (임진왜란; 壬辰倭亂)[1]-ы үед мэдэгдсэн

[1] Чосөнъ улсын 1592-1598 оны хоорондоо долоон жилийн туршид Япон улс Чосөнъ улс руу хоёр удаа довтолсноор дэгдсэн дайн.

бөгөөд 1598 он буюу Японы довтолгоон дуусаад удаагүй байх үед Орчуулгын хүрээлэн дахин байгуулагджээ. Улагчин туулай (정묘호란; 丁卯胡亂)[2], Улаан хулгана жилийн бүдүүлгийн (Манжийн) довтолгоон (병자호란; 丙子胡亂) дуусаны дараа Орчуулгын хүрээлэнд төрөөс илүү анхаарах болсон билээ. Үүнээс хойш Орчуулгын хүрээлэнгийн хэлмэрчдийн нийгэм дэх байр суурь, цаашлаад зэрэг дэв ч нэлээд ахьсан бөгөөд суралцах хүний тоо ч нэмэгдэх болжээ. XVIII зууны сүүлч буюу Чөнжо вангийн үед Орчуулгын хүрээлэнгийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, зэрэг дэвд ихээхэн анхаарах болов [Хишигцэрэн 2017: 23].

Ер нь Чосөнъ улсын үед жил бүр дор хаяж 2-3 удаа элчийн багийг Бээжин рүү илгээдэг байв. Түүний бүрэлдэхүүнд 15-20 хэлмэрч явдаг байсан нь бусад тушаалын хүмүүстэй харьцуулахад хамгийн их тоог эзэлж байжээ [Сон Кижүн 2006: 6].

Манж Чин улс байгуулагдахаас өмнө чосөнъчүүд монголчуудтай нүүр тулан харилцах нь ховор, бас дээр нь монгол бичгийн хэл хийгээд ярианы хэл зөрөөтэй байсан тул байсан тул монгол хэлний сургалт бодит хэлнээс нэлээд холдон, монгол хүнтэй нүүр тулсан монгол хэлний хэлмэрч түшмэд нь хэл нэвтрэлцэхгүй байсан тухай мэдээ ч бий. Тиймээс дээрх 3 номыг XVIII зууны дунд үед анх зохиогдсоноос хойш хэдэнтээ дахин засварлаж, хэлмэрч түшмэд Манж Чин улсад очиж тухайн үеийн ярианы хэлэнд (өвөрлөгчийн хорчин аялгуу бололтой) нийцүүлэн засаж байсан билээ.

Дээрх гурваас бусад ном, сурах бичиг эдүгээ үлдэж хоцроогүй боловч, Чосөнъ улсын гол хууль болох “Төр засах их цааз”-д тэдний нэрс үлдэж хоцорчээ.

Сөнжон ван (성종; 成宗)[3]-гийн үед зохиогдсон Чосөнъ улсын гол хууль цаазын бичиг болох “Төр засах их цааз” (경국대전; 經國大典)-ын Ёслолын цааз (禮典)-ын Хэлмэрч түшмэлийн эхний шатны шалгалтын зүйл (譯科初試)-д гадаад хэлний шалгалтын талаар нарийвчлан дурдсан агаад монгол хэлний хэлмэрч түшмэлийн орон тоо, аман шалгалт авах ном зохиолын нэрс (講書), хуулж бичих номууд (寫字) зэргийг нарийвчлан тоочсон байдаг.

Нангиад хэлнээс бусад гурван хэлээр ном хуулан бичих шалгалт авдаг байсан агаад тэдгээрийн дотроос монгол хэлээр хуулж бичих номуудын нэрийг тус бүрээр нь авч үзье. Эдгээрийн ихэнх нь монгол

---

[2] 1627 он буюу Инъжо (인조; 仁祖) вангийн 5-р онд болсон Хожуу Алтан улс (1636 онд улсын нэрийг Чин болгон өөрчилсөн) Чосөнъ улстай хийсэн дайн.

[3] Чосөнъ улсын 9 дэх ван. 1469-1494 оны хооронд төр барьсан.

нэртэй, зарим нь нангиад нэртэй ажээ. Эдгээр номын монгол нэрийг нэхэн сэргээх оролдлогыг И Кимүнъ [И Кимүнъ 1967], Сон Кижүн [Сон Кижүн 1985], Б. Сумьяабаатар [Сумьяабаатар 1975], Ж.Баттөр [Баттөр 2002], С.Батхишиг [Батхишиг 2008] нарын зэрэг гадаад, дотоодын эрдэмтэд хийсэн билээ. Гэсэн хэдий ч одоо болтол эцэслэн тогтоогүй, нэг мөр болгох шаардлагатай зүйлс байсаар байна.

王可汗 **(Ван хаган)**

Энэ номыг эрдэмтэд санал нэгтэйгээр Ван хаган гэж үздэг. Сурвалж дахь тайлбарт нь "*Ван хаган бол Юань улсын Тайцзу (Чингис хаан-Ц.Ц.)-гийн өвөг дээдэс бөгөөд "хаган" гэдэг нь нангиад хэлний "Тэнгэрийн хөвгүүн"-ийг нэрлэсэн үг болой*" гэж тайлбарлажээ (經註』224). Ван хаан цолт Тоорил бол Чингис хааны өвөг дээдэс биш, харин түүний эцэг Есүхэйтэй анд бололцсон учир Чингис хаанд эцэг мэт хүндлэгдсэн хүн бөлгөө. Энэ номыг Сон Кижүн Тоорилын тухай яриаг цуглуулж эмхэтгэсэн ном гэж үзсэнийг бид дэмжиж байна.

守成事鑑 **(Shouchengshijian, Сүсөнсагам)**

Сурвалж дахь тайлбарт нь "*Юань улсын Ханьлинь-ий бичгийн дэд сайд Алинтөмөр (*阿隣帖木兒*), Хутулу (*忽都魯*), Дүрмиши (*都兒迷實*) нарын 3 хүний орчуулсан ном*" гэжээ (經註』223). Утга нь "бүтээсэн үйлийг сахих толь" гэсэн үг. "Юань улсын судар"-т тэмдэглэснээр Ван Юнь хэмээх эрдэмтэн Өлзийт Төмөр хааны сууринд суусан он (1295 он) -д "Сүсөнсагам" 50 бүлгийг өргөн барьсан ажээ.

御史箴 **(Yushizhen, Өсажам)**

Сурвалж дахь тайлбарт нь "*Юань улсын Ханьлинь-ий бичгийн дэд сайд Алинтөмөр, Хутулу, Дүрмиши нарын 3 хүний орчуулсан ном*" гэжээ (經註』223).

高難加屯 **(Конанъ кадүнъ)**

Сурвалж дахь тайлбарт нь "*Хулан бол Юань улсын Тайцзу (Чингис хаан)-гийн хатны нэр бөгөөд Кадүнъ гэдэг нь нангиад хэлний хуанхоу-г хэлдэг*" гэжээ (『經註』224-225).

И Кимүнъ, Б. Сумьяабаатар нар энэ үгийг салгаж, хоёр өөр нэр гэж үзсэн бөгөөд И Кимүнъ "гунан" гэж үзсэн, Ж. Баттөр "Гунан хатун" гэж үзсэн бололтой. Харин С. Батхишиг Хулан хатун гэж үзсэнийг бид дэмжиж байна.

Хулан хатан бол Чингис хааны гол 4 хатны нэг бөгөөд түүний тухай ном Солонгост дэлгэрч байсны шалтгаан бол Хулан хатныг Солонгод, өөрөөр хэлбэл Солонгос хүн байсан тухай өгүүлсэн "Аргасун хуурчийн домог" монголчуудын дунд тархсан байдагтай холбоотой байж мэдэх юм. Тиймээс дээрх ном нь Хулан хатны домог, эсвэл түүнтэй төстэй агуулгатай зохиол байсан байж магадгүй.

皇都大訓 **(Huangdou daxun, Хвандо дэхүнъ)**

Сурвалж дахь тайлбарт нь "*Юань улсын Ханьлинь-ий бичгийн дэд сайд Алинтөмөр, Хутулу, Дүрмиши нарын 3 хүний орчуулсан ном*" гэжээ (『經註』223). "Юань улсын судар"-т "Хвандо дэхүнъ (皇圖大訓)" хэмээх (都 гэсэн ханзыг 圖 гэсэн ханзаар тэмдэглэсэн боловч дуудлага нь адил болой) нэр бүхий 2 ном дурдагддаг агаад тэр ном монгол хэлний сургалтад ашигладаг байсан энэ ном мөн бололтой гэж судлаачид үздэг.

乞大 **(Laoqida, Ногөлдэ)**

Энэ номын талаар өмнө тайлбарласан тул давтан нурших шаардлагагүй буй за. Нэрийн утгын талаар "Лао Кида" буюу "Лав Хятад" гэсэн монгол үг, "Үргэлж хэрэглэгддэг бичиг" гэх мэтийн олон янзын тайлбар бий.

孔夫子 **(Kongfuzi, Конбүжа)**

Сурвалж дахь тайлбарт нь "*Со-аронъ(小兒論)"-ыг монгол хэлээр орчуулсан ном*" гэжээ (經註』222).

帖月眞 **(Чөбвөлжинъ)**

Эрдэмтэд Дөрвөлжин гэж тайлсныг бид дэмжиж байна. Харин сурвалж дахь тайлбарт нь "Чөбвөлжинъ Конбүжа (帖月眞孔夫子皆飜譯小兒論)" гэсэн бөгөөд энд гарч буй "чөбвөлжинъ (帖月眞)" гэдэг нь тодорхой нэгэн номын нэр биш, дөрвөлжин үсгээр бичигдсэн номуудыг хэлж буй бололтой.

吐高安 **(Тогоанъ)**

Эрдэмтэн Б. Сумьяабаатар "Дохион" гэж үзсэн. Сурвалж дахь тайлбарт нь "*Тогоон хэмээх нь монгол хүний нэр бөгөөд агуулга нь 5 хүүхдэдээ сургаал хэлсэн тухай болой*" гэжээ (經註』223). Бас арай өөр ханзаар 土高安 гэх нь ч бий. Хэдийгээр энэ номын нэрийг "Тогоон" гэж уншиж болох ч, 5 хүүхдэдээ хэлсэн сургаал гэсэн тайлбараас нь үзэхэд Алунгоо эхийн сургаал байж магадгүй. Тиймээс

Алунгоо эхийн эр нөхөр Добун мэргэний нэрийн сунжирсан дуудлага байж болох талтай.

伯顏波豆 **(Пэганъ падү)**

Сон Кижүн “Баян баатар”, С. Батхишиг “Баян Бат” гэж үзжээ. Сурвалж дахь тайлбарт нь “*Юань улсын жанжны нэр бөгөөд түүний үгийг ном болгосон учраас номын нэр болсон ажгуу*” гэжээ. (經註』224).

Бид Баян баатар гэж үзсэнтэй санал нэг байна. “Пэганъ”-ы нангиад дуудлага нь Баян, харин “падү” нь “баатар” гэдэг монгол үг мөн болов уу. Баарин овгийн Баян бол Хубилай Сэцэн хааны итгэлт түшмэл, гарамгай жанжин бөгөөд Сүн улсыг дайлахад онцгой гавьяа байгуулсан билээ.

待漏院記 **(Dailouyuanji, Тэрүвөнъги)**

Сурвалж дахь тайлбарт нь “*Юань улсын Ханьлинь-ий бичгийн дэд сайд Алинтөмөр, Хутулу, Дүрмиши нарын 3 хүний орчуулсан ном*” гэжээ (經註』223). Угтаа энэ ном Сүн улсын үед зохиогджээ.

貞觀政要 **(Zhenguanzhengyao, Чөнгванъ жөн-ё)**

Сурвалж дахь тайлбарт нь “*Юань улсын Ханьлинь-ий бичгийн дэд сайд Алинтөмөр, Хутулу, Дүрмиши нарын 3 хүний орчуулсан ном*” гэжээ (經註』223). Энэ ном бол угтаа Тан улсын үед зохиогдсон болой.

“Юань улсын судар”-т тэмдэглэснээр 1312 онд Аюурбарвада Буянт хаан энэ номыг үзээд, Алинтөмөрт улсын хэл, өөрөөр хэлбэл монгол хэлээр орчуулж, барлахыг даалгаж байжээ (24-р дэвтэр). Бас 1332 онд Тугтөмөр Заят хаан улсын бичиг буюу дөрвөлжин үсгээр орчуулах зарлиг буулгаж байв (36-р дэвтэр). Гэвч “Юань улсын судар”-ын “Олон шастир”-ын хэсэгт энэ номын орчуулагчийг Цагаан (察罕) гэжээ (137-р дэвтэр, Олон шастир 24). Бас Цао Юаньюн орчуулсан гэх нь ч бий (172-р дэвтэр, Олон шастир 59).

速八實 **(Subashi, Согпалшил)**

Б. Сумьяабаатар “Субашид”, Сон Кижүн “Сог багш”, С. Батхишиг “Субаши” хэмээн тус тус үзжээ. Сурвалж дахь тайлбарт нь “Хүний *нэр бөгөөд түүний үгийг ном болгосон учраас номын нэр болсон ажгуу*” гэжээ. (經註』224).

Бид эрдэмтэн Б. Сумьяабаатарын саналыг дэмжиж байна. Түвэдийн сургаалын зохиол болох “Сайн үгт Эрднийн сан Субашид” буюу

товч нэрээр “Субашид”-ыг хэлж буй бололтой. Тус зохиолыг XIV зууны эхээр Сономгара хэмээх хүн монголоор орчуулсан агаад түүний орчуулга Чосөнъ улсад монгол хэлний унших бичиг болон хэрэглэгдэж байсан бололтой.

章記 **(Zhangji, Жанги)**

Судлаачид “Занги” гэсэн монгол үг гэж үзсэнийг дэмжиж байна. Сурвалж дахь тайлбарт нь “*Юань улсын эзэн хааны сургаал зарлигийг цуглуулсан ном болой*” гэжээ. (經註』222). Монгол хэлний “мэдээ занги” гэдгийн занги мөн бололтой.

何赤厚羅 **(Hechi houluo, Хажөг хүра)**

И Кимүнъ, Сон Кижүн, С. Батхишиг нар “ач үр”, харин Б. Сумьяабаатар “Шидэт хүүр” гэж таамаглажээ.

Сурвалж дахь тайлбарт нь “*Хажөг нь нангиад хэлээр “ач, тус” гэсэн үг бөгөөд “хүра” нь “хариулах” гэсэн утгатай. Сайн, муу зүйлд хариулах тухай ярианууд багтжээ*” гэжээ (經註』222). Харин “Сэжонгийн магад тэмдэглэл” (47-р боть)-д “Хажөг хүра (賀赤厚羅)” хэмээн арай өөр ханзтайгаар гардаг.

Эдгээр үгсийн нангиад дуудлага нь hechi houluo бөгөөд hechi нь монгол хэлний “ач” гэдэг үгийн дундад үеийн дуудлага бололтой. Учир нь орчин цагийн монгол хэлэнд эгшгээр эхэлдэг олон үг дундад зууны үед h-ээр эхэлдэг байсан агаад аажимдаа h нь гээгдсэн билээ. Харин houluo монгол хэлний “хариул” гэдэг үгийн нангиад галиг бололтой. Тиймээс бид “Хажөг хүра”-г “ач хариул” гэсэн монгол үг хэмээн таамаглаж байна.

巨里羅 **(Juliluo, Көрира)**

Сон Кижүн, Б. Сумьяабаатар нар “Гэрэл”, С. Батхишиг “Горира” гэж тайлжээ.

Сурвалж дахь тайлбарт нь “*Көрира нь үнэгний нэр бөгөөд түүний агуулга нь үнэг нь арслан, үхэр хоёрын хамтаар асууж хариулсан үг ярианаас бүрдэх бөгөөд Юань улсын бичгийн дэд сайд Жэгудоу (*者古斗*) орчуулсан*” гэжээ (經註』223).

Японы судлаач Мияа Норико энэ нэрийг Энэтхэгийн алдарт үлгэр болох “Калила, Димна хоёр” үлгэрийн Калила хэмээх үнэгний нэр гэж үзсэнийг [Мияа Норико 2010: 321] бид бүрэн дэмжиж байна.

ТӨГСГӨЛ

Чосөнъ улс (1392-1910) байгуулагдсан цагаасаа хөрш орнуудтай саадгүй харилцахын тулд тухайн улс орны хэлийг эзэмшсэн орчуулагч түшмэдийг бэлтгэх сургууль буюу Орчуулгын хүрээлэнг байгуулж, гадаад хэл зааж байсны нэг нь монгол хэл байсан билээ.

Орчуулгын хүрээлэнд монгол хэлний орчуулагч бэлтгэх сургалтад бараг 20 шахам ном, сурах бичиг ашиглаж байснаас эдүгээ "Монгол судлалын гурван бичиг (몽학삼서; 蒙學三書)" хэмээн нэрлэгдсэн гурван ном уламжлагдан ирсэн нь XVIII зууны монгол хэлийг судлахад чухал эх хэрэглэгдэхүүн болдог, ихээхэн үнэ цэнтэй сурвалжууд билээ.

Манж Чин улс байгуулагдахаас өмнө чосөнъчүүд монголчуудтай нүүр тулан харилцах нь ховор, бас дээр нь монгол бичгийн хэл хийгээд ярианы хэл зөрүүтэй байсан тул байсан тул монгол хэлний сургалт бодит хэлнээс нэлээд холдон, монгол хүнтэй нүүр тулсан монгол хэлний орчуулагч түшмэд нь хэл нэвтрэлцэхгүй байх тохиолдол ч гарч байжээ. Тиймээс дээрх гурван номыг анх зохиогдсоноос нь хойш хэдэнтээ дахин засварлаж, орчуулагч түшмэд Манж Чин улсад очиж тухайн үеийн ярианы хэлэнд нийцүүлэн засаж байсан билээ.

Дээрх гурваас бусад монгол хэлний ном, сурах бичиг эдүгээ үлдэж хоцроогүй боловч, Чосөнъ улсын гол хууль болох "Төр засах их цааз"-д тэдний нэрс үлдэж хоцорчээ.

Эдгээр номын монгол нэрийг нэхэн сэргээх оролдлогыг гадаад, дотоодын эрдэмтэд хийсэн боловч, одоо болтол эцэслэн тогтоож чадаагүй тул бид энэхүү илтгэлдээ тэдгээр монгол нэрсийн талаар өөрсдийн саналыг дэвшүүлсэн болно.

НОМЗҮЙ

Чосөнъ улсын магад тэмдэглэл

Баттөр 2002: *Баттөр Ж*. Солонгос судлалын өгүүллүүд. Дэд дэвтэр, Солонгост монгол хэлний хэлмэрч бэлтгэж байсан нь. УБ., 2002.

Батхишиг 2008: *Батхишиг С.*"Кёнгүг Тэжон Жүхэ"-д уламжилсан монгол сурвалжууд //Acta Mongolica, Tom. 7, УБ., 2008.

Баярмаа 2017: *Баярмаа Г.* Монгол, Солонгос хэлний хүний биеийн эд эрхтний нэрсийн харьцуулсан судалгаа ("몽어유해 Мон-ө Юхай" сурвалж бичгийн жишээгээр). Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. ОУУИХ, Их Сурхуй Хүрээлэн. УБ., 2017.

И Кимүнъ 1967: 李基文, 蒙學硏究의基本問題 //震檀學報, 31, 1967 (И Кимүнъ. Монгол судлалын судалгааны үндсэн асуудал // Чинъданъ хагбо, 31, 1967).

Мияа Норико 2010: 미야노리코지음, 김유영옮김, 조선이그린세계지도, 서울: 소와당, 2010, 321쪽 (Мияа Норико зохиов, Ким Йү-йөн орчуулав, Чосөнъ-ий зурсан дэлхийн газрын зураг. Сөүл: Совадан, 2010, т.321.

Сон Кижүн 1985: 宋基中,『經國大典』에보이는譯學書書名에대하여 // 國語學. 14, 1985 (Сон Кижүн, "Төр засах их цааз"-д гардаг орчуулга судлалын номын нэрсийн тухай // Эх хэл судлал. 14, 1985).

Сон Кижүн 2006: 宋基中, 朝鮮時代蒙古語학습과蒙學三書, 몽어노걸대: 蒙語老乞大, 다해미디어, 2006, 6쪽 (Сон Кижүн, Чосөнъ улсын үеийн монгол хэлний сургалт ба Монгол судлалын гурван ном. "Мон-ө ногөлдэ", Тахэмидиө, 2006. т.6).

Сумьяабаатар 1975: *Сумьяабаатар Б.* Монгол Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд. УБ ., 1975.

Хишигцэрэн 2017: *Хишигцэрэн Ц.* "Чосөнъ улсын магад тэмдэглэл" дэх Монголтой холбоотой мэдээ баримтыг нягтлах нь. МУИС, Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын магистрын зэрэг горилсон зохиол. УБ., 2017.

Чой Донгвөнъ, Отгонтуул 2009: 최동권, Otgontuul, T., "몽어노걸대역주", 피오디월드, 2009 (Чой Донгвөнъ, Т.Отгонтуул. "Мон-ө ногөлдэ"-гийн орчуулга, тайлбар. Пиодивөлд, 2009).